

# ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

## 2015 ОНЫ 3-Р САРД

Шилэн дансны тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд нийтдээ 28 төрлийн мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар нийтэд ил болгох ёстой. Эдгээрээс таван төрлийн мэдээллийг сонгон авч нийслэл, дүүрэг болон бүх аймаг, аймгийн төвийн сумдын нийт 52 засаг даргын тамгын газар (ЗДТГ) эдгээр мэдээллийг хэрхэн ил тод болгож байгааг 2015 оны 3 дугаар сарын 1-ээс 4 дүгээр сарын 15-ны хооронд ажиглав.




## АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮН

Мониторингод хамрагдсан аймаг, нийслэл, дүүрэг, аймгийн төвийн сумдын нийт 52 засаг даргын тамгын газрын төсвийн ил тод байдлын ерөнхий дүнг сонгож авсан мэдээллийн төрлөөр харуулав.

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий **худалдан авалт**, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг ил тод болгох /хуулийн 6.4.4 дэх заалт/


52 → 12



Нийт 12 засаг даргын тамгын газар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллээ нийтэлсэн.

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий **орлого, зарлагын гүйлгээ** тус бүрийн агуулга, хүлээн авагчийн нэрийг ил тод мэдээлэх /хуулийн 6.4.5 дахь заалт/


52 → 36



Нийт 36 засаг даргын тамгын газар цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг нийтэлсэн.

Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд холбогдох **шийдвэрийг** ил тод болгох /хуулийн 6.10 дахь заалт/


52 → 12



Зөвхөн 12 засаг даргын тамгын газар захиран зарцуулах шийдвэрээ ил тод болгосон (5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий).

**Төсвийн гүйцэтгэлийн мэдээг** сар бүр ил тод болгох /хуулийн 6.1.2 дахь заалт/

52 → 42



42 засаг даргын тамгын газар төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээгээ ил тод болгожээ.

10 сая төгрөгөөс дээш **худалдан авалтын гэрээний дүн, зарлагын мэдээллээ** улирал бүр ил тод мэдээлэх /хуулийн 6.9 дэх заалт/


52 → 5



5 ЗДТГ 10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гэрээний дүн, зарлагын мэдээллээ ил тод болгожээ.

# ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ОРОН НУТАГТ

Аймаг ба аймгийн төвийн сумдын ЗДТГ-ын ил тод болгосон мэдээллийн тоо



●	5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, ажил үйлчилгээний мэдээлэл
●	Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээлэл
●	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд холбогдох шийдвэр
●	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ
●	10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гэрээний дүн, зарлагын улирлын мэдээлэл


## ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ УЛААНБААТАР ХОТОД

А. Улаанбаатар хотын ЗДТГ-ын ил тод болгосон мэдээллийн тоо

Б. Улаанбаатар хотын 9 дүүргийн ЗДТГ-ын ил тод болгосон мэдээллийн тоо



0	5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, ажил үйлчилгээний мэдээлэл
35	Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээлэл
20	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд холбогдох шийдвэр
1	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ
0	10 сая төгрөгөөс дээш худалдан авалтын гэрээний дүн, зарлагын улирлын мэдээлэл



Доорх мэдээллийн хэрэгслүүд дээр нийтэлсэн баримтыг ажиглан мониторинг хийв.



Шилэн дансны нэгдсэн цахим хуудас



ЗДТГ-ын цахим хуудас



ЗДТГ-ын мэдээллийн самбар

Орон нутагт Шилэн дансны хууль хэрхэн хэрэгжиж байгаад Нээлттэй Нийгэм Форум иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийж, дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn) вэб сайтаас үзнэ үү.